



### ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 28

Есөнбулаг сум

#### Амралтын хөнгөлөлт эдлүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, Ахмад настны тухай хуулийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 311, 2016 оны 94 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ахмад настныг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралтад хөнгөлөлттэй нөхцөлөөр амрах амралтын үнийг хавсралтаар баталж, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажилласугай.
2. Сумдын амьжиргаа дэмжих зөвлөлийн шийдвэр, Засаг даргын тодорхойлолтыг үндэслэн амралтад амрах зардлын хөнгөлөлтийг Нийгмийн халамжийн сангаас холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.
3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралтад жилд амрах ахмадын тоог амралтын газрын хүчин чадал, боломжид тулгуурлан тогтоож ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга /М.Мянганбуу/-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 111 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

  
 ДАРГА Т.ГАНЗОРИГ

125

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн  
2017 оны 24 дүгээр сарын 24-ны өдрийн  
28 дугаар тогтоолын хавсралт



АМРАЛТЫН ХӨНГӨЛӨЛТ ЭДЛҮҮЛЭХ ҮНЭ

№	Хөнгөлөлт эдлэх хэлбэр	Ахмад настан /1 ор хоног/		Нийт 10 хоног
		Эхний 6 хоног	Сүүлийн 4 хоног	
1	Халамжийн сангаас эдлэх хөнгөлөлт	21000	13000	178000
2	Иргэн өөрөө төлөх төлбөр	0	8000 /4 хоног/	32000
3	Ор хоногийн нийт төлбөр	21000	21000	210000

-----000-----000-----000-----